



Манлайлах чадвараа хөгжүүл: **Ажиллахаа болиод удирдаж эхэл**

Бид ихэнхдээ тэргүүлэх ажилтнуудаа удирдах албан тушаалд дэвшүүлэх хандлагатай байдаг. Үр дүнтэй гүйцэтгэл сайтай ажилтныг бид үр ашигтай, чадварлаг манлайлагч болно гэж үздэг ч ихэнх тохиолдолд удирдах ур чадвар, сэтгэлгээ нь огт өөр, шилжилт нь илүү хэцүү, удаан болж, ихэнхдээ бүтэлгүйтдэг.

Энэ үед тулгардаг хэцүү зүйл нь хамтран ажиллагсдаа удирдах нөхцөл байдалд бэрхшээл тулгардаг. Шинэ удирдлагууд өөрсдийнхөө гүйцэтгэлд хариуцлага тооцохоос илүү бусдын үр дүнд хариуцлага хүлээх нь илүү чухал байдаг. Шинээр томилогдсон удирдах ажилтан удирдах талбараа орхигдуулж илүү гүйцэтгэлд анхаарах нь элбэг байдаг нь эргээд л хүн бүрийн ажлыг өмнөөс нь хийх гээд байдаг хандлага байдаг. Энэ нь компанийн хүссэн үр дүн биш юм.

Эдгээр нийтлэг алдаанаас зайлсхийж, манлайллын шугамаа барьж эхлэх нь туйлын чухал. Шинээр гарч ирж буй удирдагчид болоод удирдах албанд бэлтгэгдэж буй ажилтан сайн удирдагчаас үр дүнтэй, хүндлэл хүлээсэн удирдагч руу шилжих чадварыг энэхүү сургалт өгөх болно.

Энэхүү хөтөлбөр нь уламжлалт манлайллын сургалтын хөтөлбөрүүдээс илүүтэй тул хүчирхэг баг бүрдүүлэх, ур чадвараа хөгжүүлэх, хариуцлагатай байдлыг бий болгох, зөв хандлагатай болоход шаардлагатай ур чадварыг хөгжүүлнэ. Энэхүү хөтөлбөр нь шинэ удирдагчдын өмнө тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх, сэтгэлгээгээ өөрчлөхөд туслах, хамгийн амжилттай удирдагчдын ашигладаг батлагдсан стратеги, арга техникүүдтэй олон улсын шинэ хөтөлбөр юм.

Энэхүү хөтөлбөрийн талаар илүү ихийг олж мэдэхийг хүсвэл бидэнтэй холбогдоорой. Дэйл Карнегийн манлайллын хөтөлбөр нь олон нийтэд зарласан хөтөлбөрүүдээс гадна байгууллагад зориулсан тусгай шийдлээр танай байгууллагын залгамж халааг бэлдэхэд туслах болно.

Хичээлийн сэдвүүд:

- Үнэнч, шударга байдал
- Өөрийгөө таньж чаддаг байдал
- Бусдад эергээр нөлөөлөх чадвар
- Урам зориг өгөх чадвар
- Бусад анхаарлаа төвлөрүүлэх байдал
- Хариуцлага тооцох чадвар
- Мэргэжлийн байдал
- Эрх мэдлийг зохих ёсоор ашиглах
- Өөрийгөө тогтмол хөгжүүлэх чадвар
- Бусдыг хөгжүүлэх чадвар
- Үр дүнтэй харилцах ур чадвар
- Өөртөө итгэлтэй байдал
- Өөрөө ухамсарлах
- Өөрийгөө зохицуулах

Хэн хамрагдах вэ?

Шинээр гүйцэтгэх удирдлагад ажиллаж эхэлж байгаа захирал, удирдлагууд мөн байгууллагын өндөр гүйцэтгэл сайтай удирдах албан тушаалд өөрийгөө бэлдэж байгаа хувь хүмүүс, байгууллагын бодлогоор бэлтгэж байгаа удирдах ажилтнуудад тохиромжтой.

ДЭЙЛ КАРНЕГИ АКАДЕМИ

Хэрвээ та энэхүү хөтөлбөрийн цогцоор нь урт хугацааны академийн хөтөлбөр сонирхох бол жилд нэг удаа зарлагддаг хүчирхэг удирдагч бэлтгэх хөтөлбөрийн сонирхоорой.